



“АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

20 18 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Авилгын эсрэг хуулийг хэрэгжүүлэх
арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Арилжааны төлбөр тооцоо ҮЦК” ХХК-ийн Дүрмийн 8.10.11, Авилгын эсрэг хуулийн 5, 6 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйл, Сангийн яамны 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 11/7414 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн 2018 онд Авилгын эсрэг хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу холбогдох ажлыг зохион байгуулж тайлан, гүйцэтгэлийг тогтмол гарган танилцуулахыг эрх бүхий албан тушаалтан /А.Баярмагнай/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн албаны дарга /А.Ганзориг/-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.ЭРДЭНЭГЭРЭЛ

“АТТ ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2018 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн
АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО

АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО
ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
0011004-0017724462

“АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК-ийн Авилгын эсрэг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан
2018 онд хийгдэх ажлын төлөвлөгөө

№	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан	Тайлбар
Нэг. Хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх					
1	Авилгын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах, урьдчилан сэргийлэх, мэдээлэл чөлөөтэй авах нөхцлийг хангах	1.1 Мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэвлэмэл материал гэх мэт	Тухай бүр	Бүх албад	Тухайн онд төлөвлөсөн төсвийн хүрээнд мэдээллийг түгээх
		1.2 Авилгатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд байгууллага, албан хаагчдад түгээх бүртгэл хөглөх	Тухай бүр	Бүх албад	Мэдээллийг тэгш, шуурхай хүргэх
2	Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах	2.1 Өмнөх оны гүйцэтгэл, Тухайн жилийн, хагас жилийн, улирлын, сарын төсвийн гүйцэтгэл, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх	Тухай бүр	Ерөнхий нягтлан бодогч	Шилэн дансны хуулийн дагуу цахимаар дамжуулан тогтмол үнэн зөв мэдээлэх
		2.2 Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг мэдээлэх	Тухай бүр	ТТЭУ алба	-
3	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах	3.1 ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, Ерөнхий нягтлан бодогчийн мэдээллийг цахим хуудсандаа мэдээлэх	Тухай бүр	ЗСА	Компанийн вэб сайтаар дамжуулах
		3.2 Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах	Тухай бүр	ЗСА	-
4	Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах	Үндсэн үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох дүрэм, журам, маягтыг мэдээлэх	Тухай бүр	Гүйцэтгэх удирдлага, ТТЭУ	Компанийн вэб сайтаар дамжуулах
5	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	5.1 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах	1 сарын 10-ны өдрийн дотор	ЗСА	Шилэн дансны тухай хуулийн дагуу
		5.2 ЗГ-аас баталсан тогтоолын дагуу “босго	Тухай бүр		АТГ-ын зөвлөмжийн дагуу



		үнэ"-ийг баримтлан ажиллах 5.3 Тендерийн үнэлгээний хороонд төрийн зохих байгууллагын албан тушаалтнуудыг оролцуулах	Тухай бүр		
6	Авилгын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авилгатай тэмцэх газар болон Сангийн яамтай харилцах эрх бүхий албан тушаалтныг томилох	Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон ХОМ-ыг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмын дагуу ЭБАТ томилох	Тухай бүр	Гүйцэтгэх удирдлага, ЭБАТ	Гүйцэтгэх захирлын тушаалаар
7	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/ гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх	Дотоод хяналтын журамд заасны дагуу арга хэмжээг авч ажиллах	Тухай бүр	Дотоод хяналтын ажилтан, Захирлын туслах	-
8	Авилгатай тэмцэх газар, Сангийн яамнаас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	Шийдвэрт заагдсан шаардлагатай арга хэмжээг авч ажиллах	Тухай бүр	Холбогдох албан тушаалтан	-
9	Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх	Байгууллагын нийт ажилтнуудад сургалт зохион байгуулах	Жилд 1 удаа	ЭБАТ	-
Хоёр. Авилгатай тэмцэх зөвлөмжийн хүрээнд /АТГ-ын 2017.12.05 өдрийн 01/8723 албан бичиг, Сангийн яамны 2017.12.28 өдрийн 11/7414 албан бичиг/					
10	Батлагдсан орон тооны хязгаарын хүрээнд томилгоо хийх	2018 оны Бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшиний дагуу	Тухай бүр	ЗСА	-
11	Нийтийн албанд томилгоогоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсны дараа ажилд томилох	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу	Тухай бүр	ЗСА, ЭБАТ	-
12	Нийтийн албан тушаалтан Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд гаргах, хяналтыг чангатгах	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу	Тухай бүр	ЗСА, ЭБАТ	-
13	Худалдан авах чиглэлээр мэргэшсэн (АЗ сертификат бүхий) ажилтанг бэлтгэх, зардлын эх үүсвэрийг шийдвэрлэх, уялдаа холбоог сайжруулах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бара, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу	Тухай бүр	ЗСА	-